


Аудит хийгдсэн байгууллага:
СҮХБААТАР АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

**ДОТООД АУДИТЫН НЭГЖ: СҮХБААТАР АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБА**

- ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН -

Аудитын нэр: Дотоод аудит
Жил: 2021, 2022 он

2023 он



АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА: СҮХБААТАР АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА

АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: СУХБААТАР АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

АУДИТЫН ТӨРӨЛ: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДОТООД АУДИТ


АУДИТЫН ХУГАЦАА : 30 ХОНОГ

Аудитын багийн ахлагч :

Ахлах дотоод аудитор Х.Хүрэлцэцэг

Аудитын багийн гишүүн:

Дотоод аудитор Б.Буджав



1. ТАНИЛЦУУЛГА

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

2.2 Аудитын цар хүрээ

3. Байгууллагын сайн туршлага

3.1. Засаглалын удирдлагын талаар

3.2. Эрсдэлийн удирдлагын талаар

3.3. Дотоод хяналтын талаар

4. АУДИТЫН ҮР ДҮН

4.1. Илэрсэн асуудлууд

5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ



1. ТАНИЛЦУУЛГА

Сүхбаатар аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн нэгдсэн төлөвлөгөө, албаны даргын баталсан Дотоод аудитын 01 тоот удирдамжийн дагуу Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэсэн тайланг танилцуулж байна.

Байгаль орчин аялал жуулчлалын газар нь 2000.12.29 өдөр, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар явуулж байгаа төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага болон байгууллагдсан.

Байгууллагын эрхэм зорилго:

Орон нутгийн төрийн захиргаа, олон нийтийн оролцоотойгоор байгаль орчны салбарын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалж, байгаль орчны тогтвортой хөгжлийг хангахад оршино.

Аймгийн засаг даргын 2023 оны А/118 захирамжийн дагуу дарга-1, мэргэжилтэн - 10, бичиг хэрэг, архив-1, нягтлан бодогч -1, жолооч-1, нярав-1, үйлчилэгч-1, байгаль хамгаалагч-13, байгаль орчны хяналтын улсын байцаагч -3, бичигт боомтын хураамжийн ажилтан-1 нийт 33 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. 2023 оны 3 дугаар сараас эхлэн тус газрын даргын түр орлон гүйцэтгэгчээр ахлах мэргэжилтэн Ш.Нямхүү томилогдсон.

Үйл ажиллагааны чиглэл:

Газар нь аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Засгийн газрын холбогдох агентлагууд, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, Засаг даргын захирамж, шийдвэрийг удирдлага болгон Тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа, усны сав газрын захиргаа, аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэстэй ажлын уялдааг хангаж ажиллана.

Аймгийн хэмжээний байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийг дэлгэрүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар тогтмол хангаж хэрэглэгчдийг байгаль орчин, аялал жуулчлалтай

холбогдолтой мэдээллээр хангах, экологийн боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго:

Байгаль орчин аялал жуулчлалын газрын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар байгууллагын ажлын үр дүнг нэмэгдүүлэх зорилготой.

2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт:

-2021-2022 оны жилийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, цалин хөлс тогтоолт, олголт өр авлага, түүний бууруулалт

-Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалт зарцуулалтын байдал, анхан шатны болон няглан бodoх бүртгэлийн хөтлөлт, худалдан авах ажиллагаа

-Сүхбаатар аймгийн Төрийн аудитын газар нь “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийн хэрэгжилт нийцлийн аudit хийсэн тул

- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэргийг хязгаарласан болно.

2.3 Аудитын арга, аргачлал:

Дотоод аудитаар байгууллагын удирдлагад дотоод аудитын зорилго, хэрэгжүүлэх зарчмаа танилцуулж, засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны талаар асуулга авсан. Мөн аудитын хамрах хүрээнд багтаасан асуудлуудын хүрээнд байгууллагаас олж авсан мэдээлэл, бичиг баримтад дун шинжилгээ хийж эдгээрийн үр дүнд дотоод аудитын нотолгоо цуглуулж, аудитын дүгнэлтээ гаргасан болно. Дотоод аудитыг хэрэгжүүлэхэд дараах хууль эрх зүйн баримтуудыг эх үүсвэр болгон ашиглалаа.

- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
- Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль
- Усны тухай хууль
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Амьтны тухай хууль
- Байгалийн ургамлын тухай хууль



- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бус
- Агаарын тухай хууль
- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
- Хог хаягдлын тухай хууль
- Химиин хорт болон аюултай бодисын тухай хууль
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- Аялал жуулчлалын тухай хууль

Ерөнхийлөгчийн зарлиг

- Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр зохион байгуулах тухай


3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

Өнгөрсөн онуудад байгаль орчны чиглэлийн 5 төрийн бус байгууллагад 82 орчим иргэд эвлэлдэн нэгдэж, үйл ажиллагаа явуулж байгаагийн зэрэгцээ 49,512 мянган га талбай газрыг гэрээгээр хариуцуулан, хамгаалж байна. Энэ ажлын үр дүнд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг тогтвортой ашиглах, нөхөн сэргээх ажилд ялангуяа, байгалийн нөөцийн хууль бус ашиглалтыг таслан зогсоох, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажилд дэвшил гарч байгаагийн зэрэгцээ нутгийн иргэдийн ажлын байр, орлогын эх үүсвэр ч нэмэгдэх боломжтой харагдаж байна.

Мөн тус газар нь өнгөрсөн онуудад Хустайн байгалийн цогцолборт газраас 280 толгой Монгол тарвагыг Дарьганга, Сүхбаатар, Түмэнцоогт, Эрдэнэцагаан, Мөнххаан суманд сэргээн нутагшуулсан байна. Тарвага сэргээн нутагшуулснаар экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, хөрсний доройтол, цөлжилтийг сааруулах, ургамалжилт болон ургамал нөхөн сэргэхэд чухал үүрэгтэй байна. Аймгийн хэмжээнд ховор амьтан болох Аргаль хонь, Халиун буга, Хар сүүлт, Цагаан зээр зэрэг амьтдыг хамгаалах талаар жил бүр хяналт шалгалт, мониторинг хийж хэрэгжүүлж, хоол тэжээлийн хомсдолд орохоос сэргийлж 19.5 сая төгрөгийн биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлсний дунд эдгээр амьтдын тоо толгой, тархац нутаг нэмэгдсэн байна.

3.1 Засаглалын талаар:

Газар нь аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж, байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Засгийн газрын холбогдох агентлагууд



Иргэдийн төлөөлөгчдийн хурал, тэдгээрээс гарсан шийдвэр тогтоолыг удирдлага болгон ажилладаг.

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/76 тоот тушаалаар газар нь үүрэг зорилгоо хэрэгжүүлэх ажлын уялдаа холбоог хангах зорилгоор байгал орчин, аялал жуулчлалын газрын даргад зөвлөх эрх бүхий зөвлөлийг ажиллуулна. Зөвлөлийн бүрэлдэхүүнд аймгийн Цаг уур орчны шинжилгээний албаны дарга, Газрын албаны дарга, Тусгай хамгаалалтын захиргааны дарга, усны Сав газрын дарга, аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, ойн нэгжийн асуудал хариуцсан дарга эсхүл ойн асуудал хариуцсан мэргэжилтнийг тус тус оруулна гэж заасан. Гэвч уг зөвлөл байгуулагдаагүй, ажиллах журмаа газрын даргаар батлуулаагүй байна.

2021-2022 онуудад өөрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны 2020-2028 оны стратеги төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан, шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, тухайн жилийн зорилтот түвшин, гүйцэтгэл, үр дүнг тооцсон байна.

2021 онд Аймгийн Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 бүлэг, 14 зорилт, 81 арга хэмжээ хийхээр гэрээ байгуулан ажилласан. Жилийн эцсийн байдлаар 84.7 хувийн биелэлтэй.

2022 онд Аймгийн Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 бүлэг, 13 зорилт, 76 арга хэмжээ хийхээр гэрээ байгуулан ажилласан. Жилийн эцсийн байдлаар 95.0 хувийн биелэлтэй.

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/18 дүгээр захирамжаар бүтэц, орон тоог шинэчлэн баталсан.

Засаглах удирдлагын төлөвшлийг томьёолсон буюу 3 дугаар түвшинд байна гэж дүгнэлээ.

3.2 Эрсдэлийн удирдлагын талаар:

Эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлого журамгүй, эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлоогүй, түүнийг удирдах, үе шатыг тогтоох, бууруулах талаар нэгдсэн мэдээлэл байхгүй байгаа боловч нэгж ажилтан бүр өөрийн чиг үүрэгт хамаарах асуудлын хүрээнд тулгарч буй хүндрэл бэрхшээл, учирч болох эрсдэлт хүчин зүйлсийн талаар ойлголттой байна. Байгууллагад тулгарч буй эрсдэлийг тодорхойлох ба үнэлэх зарчим, үйл явц нь байгууллагын зорилготой уялдсан,



тодорхой эрсдэлийг хэрхэн удирдаж байгаа талаар дүн шинжилгээ хийх, үүнийг үнэлэх явцад залилангийн үйл ажиллагаа оршин байгаа эсэхийг дотоод хяналтын нэгж, даргын зөвлөл харгалзан үздэггүй байна. Эрсдэлийг зөвшөөрөх түвшинд хүртэл бууруулах хяналтын түвшинг тодорхойлоогүй.

Хүний нөөц сургалт сурталчилгаа хариуцсан ажилтны орон тоо дээр мэргэжилтэн байхгүйгээс, аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн нь давхар хийж байгаа нь аялал жуулчлалыг төрөөс баримтлах нэгдсэн бодлого алдагдах, түүнийг орон нутагт хэрэгжүүлж, зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэг алдагдах эрсдэлтэй байна.

Мөн Сүхбаатар, Уулбаян, Түвшинширээ сумдад байгаль хамгаалагчийн орон тоо дутуу байгаагаас, уг ажлын байран дах ажил үүрэг хийгдэхгүй орхигдох нөхцөл байдал үүссэн.

Байгууллагын эрсдэлийн төлөвшлийг эхлэлийн буюу 1-р түвшинд байна гэж дүгнэлээ.


3.3. Дотоод хяналтын системийн талаар:

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын дагуу Газрын даргын 2023 оны А/08 тоот тушаалаар дотоод хяналтын нэгжийг 3 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсан байна.

2021 онд дотоод хяналт шалгалт хийх 3 бүлэг 26 арга хэжээ, 2022 онд мөн 3 бүлэг 26 арга хэмжээ хийхээр төлөвлөжээ. Гэвч дотоод хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхдээ, засгийн газрын 2020 оны 206 тоот, аймгийн засаг даргын 2021 оны А/343 тоот захирамжийг удирдлага болгон хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу өөрийн байгууллагын онцлог үйл ажиллагаанд тохирсон “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-ыг боловсруулахдаа өмчийн буртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү буртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт; хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд тавих хяналт шалгалтыг орхигдуулсан.

Дотоод хяналтын нэгж нь жил бурийн эхэнд төлөвлөгөө батлуулж ажилдаг боловч дотоод хяналт шалгалтыг үр дүнтэй зохион байгуулж ажилладаггүй. Дотоод хяналт шалгалтын дүнг даргын зөвлөлөөр хэлэлцүүлж, хамт олны шаардлагатай тохиолдолд хамт олонд мэдэгддэггүй.



ДОТООД АУДИТЫН НАЖЛЫН БАРИМТ. АБ4000

Дотоод хяналтын тогтолцооны төлөвшлийг 2-р түвшин буюу давтамжтай түвшинд байна гэж дүгнэлээ.

3.4. Өмнөх дотоод аудитын зөвлөмжийн биелэлтийн талаар:

Дотоод аудит хийгдэж байгаагүй.

4. АУДИТЫН ҮР ДҮН

Илэрсэн асуудал 4.1	Дотоод хяналтын нэгж хангалттай ажиллаагүй.
Асуудлын ангилал	Нэлөө ихтэй
Бодит байдал: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу өөрийн байгууллагын онцлог үйл ажиллагаанд тохирсон “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-ыг боловсруулахдаа өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт; хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд тавих хяналт шалгалтыг орхигдуулсан.	
Дотоод хяналтын нэгж нь жил бурийн эхэнд төлөвлөгөө батлуулж ажилдаг боловч дотоод хяналт шалгалтыг үр дүнтэй зохион байгуулж ажилладагүй. Дотоод хяналт шалгалтын дүнг даргын зөвлөлөөр хэлэлцүүлж, хамт олны шаардлагатай тохиолдолд хамт олны мэдэгдэггүй.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67.1-д /Төрийн өмчтэй хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно. Засгийн газрын 2011 оны “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” 311 дүгээр тогтоол, 3.7.1 зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах.	
Асуудлын үндсэн шалтгаан: Дотоод хяналтын нэгжийн албан хаагчид нь төсөв, санхүүгийн талаар мэдлэг дутмаг, хийх ажлын төлөвлөгөөндөө тусгаагүй.	
Байгууллагад үзүүлэх нэлөө /үр дагавар/: Байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагаанд даа дүгнэлт хийж чадахгүй, хууль, тоогоомж, дүрэм журам зөрчигдөх.	
Зөвлөмж: Дотоод хяналтыг хийхдээ албан хэрэг хөтлөлт болон өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хийхийг төлөвлөгөөнд тусгаж ДХШ-г хийж, тайланг удирдлага хамт олонд танилцуулж байх.	



ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

Илэрсэн асуудал 4.2	Байгаль орчны байцаагч нар нь өрөө тасалгаагүй, байгууллагын коридорт ажиллаж байна.
Асуудлын ангилал	Нэлөө их
Бодит байдал: Байгаль орчны хяналтын улсын байцаагч нар нь ажлын албан өрөөгүй, үүдний хэсэгт ширээ сандал албан хэрэгсэл нь ил задгай, байрлаж байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Монгол улсын үндсэн хуулийн 46 дугаар зүйл 46.3-т “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно”, “Төрийн албаны тухай хууль”-ийн 61 дүгээр зүйл 61.1.2 албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангуулах, Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын дэс түшмэлийн болон түүнтэй адилтгах албан тушаалтанд ногдох өрөөний талбайн хэмжээ тавилга хэрэгсэл-ийг норм хэмжээг зөрчсөн тус тус зөрчсөн байна.	
Асуудлын үндсэн шалтгаан: Өрөө тасалгааны хүрэлцээ хангамж муу, байцаагч нарын орон тоо нэмэгдсэн	
Үр нэлөө: Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа хангагдахгүй байх, бичиг баримт алдагдах	
Зөвлөмж: Дарга, удирдлага-д Өөрийн нөөц боломжиндоо тулгуурлан өрөө, тасалгааг зохицуулах	

Илэрсэн асуудал 4.3	БОАЖГ-Н Даргад зөвлөх эрх бүхий зөвлөлийг байгуулж, ажиллаагүй байна
Асуудлын ангилал	Нэлөө их
Бодит байдал: Даргад зөвлөх эрх бүхий зөвлөлийг байгуулж ажиллаагүй.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/76 тоот тогтоолын 2.1 Газар нь үүрэг зорилгоо хэрэгжүүлэх ажлын уялдаа холбоог хангах зорилгоор газрын даргад зөвлөх эрх бүхий зөвлөлийг ажиллуулна. Зөвлөлийн бүрэлдэхүүнд аймгийн Цаг уур орчны шинжилгээний албаны дарга, Газрын албаны дарга, Тусгай хамгаалалтын захиргааны дарга, усны Сав газрын дарга, аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, ойн нэгжийн асуудал хариуцсан дарга эсхүл ойн асуудал хариуцсан мэргэжилтнийг тус тус оруулна гэж заасан	
Асуудлын үндсэн шалтгаан: -Зөвлөлийг байгуулаагүй -Зөвлөлийн ажиллах журмыг батлуулаагүй	
Үр нэлөө: Байгууллагын хамтын ажиллагаа болон үйл ажиллагааны төлөвлөгөө буруу хийгдэх эрсдэлтэй	
Зөвлөмж: Дарга удирдлага-д Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/76 тоот	



Илэрсэн асуудал 4.4	Усны нөөц түүнийг зохистой ашиглах талаар хяналтаа хангалттай сайн тавьж хэрэгжүүлдэггүй.
Асуудлын ангилал	Нэлөө их
Бодит байдал: Цэвэр усан хангамжийн эх үүсвэр аймгийн төвөөс урагш 30 км-т орших Шарга Шовдолын уулын ар хормойн газар доорх усны 2 усан санд нөөцөлж өөрийн даралтаар 24 цагийн турш усан хангамжийн төвлөрсөн системд холбогдсон хэрэглэгчдийг, харин гэр хорооллыг 21н ус түгээх цэгээс хангаж байна. Дээрхи усан сангуд нь 1994 онд ашиглалтад орсон бөгөөд олон жилийн ашиглалтаас болж сардаа 2000м3 ус буюу нийт олборлосон усны 30 хувийг усан сангудын нэвчилтээр алдаж байгаа бөгөөд манай аймаг нь усны нөөц багатай аймгийн тоонд судалгаагаар орсон.	
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Байгаль орчны газар нь "Усны тухай хууль"-ийн 18 дугаар зүйлийн 18.1.3 Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, усан орчинг нөхөн сэргээх, ус хангамж, ариутгах татуургын болон хаягдал ус зайлцуулах үйл ажиллагаанд хяналт тавьж хэрэгжүүлнэ,
Асуудлын үндсэн шалтгаан:	-Усны алдагдлыг бууруулах чиглэлээр улсын байцаагчийн дүгнэлт гаргуулах -Холбогдох байгууллагыг мэдээллээр хангаж, усны алдагдал оруулж байгаа үндсэн шалтгааныг мэргэжлийн байгууллагатай хамтарч гаргах
Зөвлөмж: Дарга удирдлага болон холбогдох мэргэжилтэнд Хариуцсан байгууллагад усны алдагдлын талаар хяналтыг тавьж хэрэгжүүлэх, түүнийг бууруулах талаар, эрх бүхий албан тушаалтыг мэдээллээр хангах	

Илэрсэн асуудал 4.5	Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа бүх төслийд бүгд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хамрагддаггүй.
Асуудлын ангилал	Нэлөө их
Бодит байдал: 2021, 2022 онуудад байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг 17 аж ахуйн нэгж байгууллага хийлгэсэн. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг зөвхөн хүсэлт ААНБ-ын дагуу хийсэн байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/:	"Байгаль орчныг хамгаалах тухай хууль"-ийн 9 дүгээр зүйлийн 9.2 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна, "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.3 Төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт, тухайн сум,



ДОТООД АУДИТЫН ЗАХЛЫН БАРИМТ АБ4000

дүүргийн Засаг даргын санал болон холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн энэ хуулийн хавсралтад заасан ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллага, эсхүл байгаль орчны албанад байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ гэж заасан

Асуудлын үндсэн шалтгаан:

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилт хангагдаагүй.
- Холбогдох байгууллагыг мэдээллээр хангаж, байгаль орчны улсын байцаагчтай хамтран ажиллах

Зөвлөмж: Дарга удирдлага болон холбогдох мэргэжилтэнд

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хамрагдах аж ахуйн нэгж байгууллагын тоог нэмэгдүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангах талаар сургалт сурталчилгааг олон нийтэд явуулах, эрх бүхий албан тушаалтныг мэдээллээр хангах

5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Дүгнэлтийн төрөл

Сайжруулах шаардлагатай

Дүгнэлтийн тайлбар

Байгууллагын үйл ажиллагааны төлөвшилжийн томъёолсон буюу 3 дугаар түвшинд байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн асуудлуудын 50 хувийг нь нөлөө ихтэй гэж үзсэн.

Дотоод аудитаар илэрсэн асуудлуудад өгсөн зөвлөмжийн биелэлтийн тайланг 2023 оны 09 дугаар сарын 30-ны дотор ирүүлэх.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

АХЛАХ ДОТООД АУДИТОР

Х.ХҮРЭЛЦЭЦЭГ

ДОТООД АУДИТОР:

Б.БУДЖАВ

ТАНИЛЦСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.НЯМХҮҮ

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН
САЛБАРЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ,
ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН МЭРГӨЖИЛТЭН Ц.ӨӨҮҮНГЭРЭЛ

